



# БҮГД НАЙРАМДАХ НАМ

## REPUBLICAN PARTY

2007 оны 07 сар 25

Дугаар 05

Улаанбаатар хот

### БҮГД НАЙРАМДАХ НАМЫН ЭЭЛЖИТ БУС 2 ДУГААР ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Бүгд Найрамдах Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай

Намын дүрмийн 16.3, 16.4.1, Улс төрийн намуудын тухай хуулийн 13.2.1 заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

- 1 БНН-ын дүрмийн 20.1-р зүйлд заасан УТЗ-ийн "21" гишүүн гэснийг "31" хүртэл гишүүн болгон өөрчилсүгэй.
- 2 Намын дүрмийн 16.4.2-т зааснаар Бага Хурлын гишүүдийг шинээр сонгосугай.
- 3 БНН-ын "Эрхэм таван зорилго"-д нийцүүлэн 2008 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох намын мөрийн хөтөлбөрийг 15 хүртэл заалттайгаар шинэчлэн баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:	Б. ЖАРГАЛСАЙХАН
ТӨРГҮҮЛЭГЧИД:	Б. НЯМСҮРЭН
	Б. ЗОРИГОО
	Ч. ГАНБОЛД
	П. ДОГМИДМАА

**БҮГД НАЙРАМДАХ НАМЫН  
2008 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Дараахь 11 зүйлийг Бүгд Найрамдах Нам мөрийн хөтөлбөртөө тусгаж байна:

**1. Хүнсний аюулгүй байдал, хангамж:**

Улсын хэмжээний хүнсний нөөцийг бий болгох төрийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ. Ингэснээр:

- хүнсний аюулгүй байдал, чанар, стандартыг сайжруулна.
- Хүнсний баталгаат нөөцтэй болно.
- Малын хулгайг бүрэн арилгана.

**2. Ногоон бүс-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл:** Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймаг манай улсын үржил шимт хөрстэй, ой мод, усны эх ундаргатай бүс нутаг тул дархан цаазтай ногоон бүс болгоно. Аялал жуулчлал, усжуулалттай эрчимжүүлсэн газар тариалан, ногооны аж ахуй, гахай, шувуу, сүүний болон махны чиглэлийн фермерийн аж ахуйнуудыг хөгжүүлнэ. Үүний тулд:

- Тус бүс нутагт алт олборлолтыг бүрэн хориглоно.
- Дархан хот, Багануур дүүрэгт хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн сургалт, засвар үйлчилгээний төвийг шинээр байгуулна.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг татвараас 100 хувь чөлөөлж, бага хүүтэй зээл олгоно.

**3. Архи, спиртийн үйлдвэрийг төрийн мэдэлд 100 хувь авна.**

- архи, спиртийн онцгой татварыг нэмэгдүүлнэ.

**4. Хүүхдийн мөнгө:** Төрөөс хүүхдэд сар тутам олгодог мөнгийг 20,000 төгрөгт хүргэнэ.

**5. Хүн амын эрүүл мэнд:** Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн үнэ төлбөргүй үзлэгт нэгдсэн журмаар хамруулж, хүн амаа эрүүлжүүлнэ. Иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалыг сайжруулна.

Улаанбаатар хотын зургаан дүүргийг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж бүхий тохилог клиник, эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгтэй болгоно.

Дархан, Эрдэнэт, Багануурын эмнэлгүүдэд засвар үйлчилгээ тохижилт хийж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд ая тухтай, соёлтой, чанартай үйлчилгээ үзүүлдэг болгоно.

**6. Боловсрол-хүмүүжил:** Багш төвтэй сургалт явуулж хүүхдийн хүмүүжилд анхаарна. Мэргэжлийн сургалтын төвүүдийг байгуулна.

Их, дээд сургуулиудад улс орныг үйлдвэржүүлэхэд нэн шаардлагатай инженер, техникийн мэргэжилтэн бэлтгэхэд түлхүү анхаарч сургалтын материаллаг баазыг шинэчлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

**7. Үйлдвэр технологийн паркууд:** Эрдэнэт, Дархан, Улаанбаатар, Хөтөл, Багануурыг үйлдвэрлэлийн цогцолбортой болгон хөгжүүлнэ. Эдгээр үйлдвэрлэлийн паркийн цогцолборт бүрэн автоматчилагдсан, компьютерийн удирдлагатай, орчин үеийн өндөр технологи нэвтрүүлнэ. Аймгийн төвүүдэд хөнгөн хүнсний үйлдвэр болон барилгын материалын жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ.

8. Хүнд үйлдвэрлэл, хөгжлийн зүтгүүр төслүүдийг хэрэгжүүлнэ:

1. Нүүрс төсөл
2. Зэс төсөл
3. Уран төсөл
4. Төмөр төсөл
5. Эрчим хүчний төсөл
6. Таван толгой, Оюу толгой төсөл

9. "Орон сууц" хөтөлбөр: Хот, суурин газрын агаар, хөрсний бохирдолтын асуудлыг шийдэх, цэвэр, тохилог орчин бүрдүүлэх, бага, дунд орлоготой, гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлнэ.

10. Төрийн албан хаагчийн хариуцлагын тогтолцоо:

- Төрийн мэргэшсэн албыг намын харъяаллаас чөлөөлнө.
- Авилгатай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
- Яам, агентлагуудын ажлын хариуцлагыг эрс сайжруулна.

11. Банк, санхүүгийн тогтолцоо:

- Банк, санхүүгийн системийг бүхэлд нь эрүүлжүүлнэ.
- Хөгжлийн хөрөнгө оруулалтын банк байгуулна.
- Мөнгөний гүйлгээг боловсронгуй болгон хяналттай болгоно.



БҮГД НАЙРАМДАХ НАМ